

## АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

**I. ТӨСӨВ:** 2013 оны 1-р сарын 1-нээс “Төсвийн тухай хууль” шинээр хэрэгжиж эхлэснээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, соёлын байгууллагууд, хүүхэд гэр бүлийн хэлтэс, газрын алба, халамж асрамжийн үйлчилгээ зэрэг зардлууд орон нутгийн төсвөөс санхүүжих болсонтой холбоотойгоор төсвийн зардал ихээр нэмэгдэж байна.

Мөн орлогын хувьд орон нутагт төвлөрдөг байсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, лицензийн төлбөр нь улсын төсөвт төвлөрдөг болсон. Дээр нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулдаг болсон.

Аймгийн төсвийн орлогод 3.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 6.2 хувиар биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 2.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 50.6 тэрбум төгрөгт хүрсэн нь 2012 оны жилийн эцсээс 3.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 25.4 тэрбум төгрөг болсон нь 2012 оны жилийн эцсээс 0.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Малын онд оролт: Энэ онд 2280.6 мянган мал онд орж байгаа бөгөөд эхний 1 сард оны эхний малын 0.12 хувь болох 2.8 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.88 хувьтай байна.

Нийт хорогдсон малын 52.8 хувь нь ямаа, 40.7 хувь нь хонь байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл: Дарьганга, Мөнххаан, Асгат, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдын оны эхний малын 0.19-1.04 хувь болох 2.4 мянган мал хороогдоод байгаа нь нийт хорогдлын 85 гаруй хувийг эзэлж байна.

Наран, Сүхбаатар, Халзан сумд мал хорогдоогүй гэж мэдээлсэн байна.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3.1 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 36.3 сая төгрөгөөр дээгүүр, оны үнээр 6.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 1.8 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс ул боов, хиам, цайрын баяжмал, дулаан, сандал, хаалга, оёдол болон төмөр эдлэлийн үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 1.5 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 1.6 хувиар, тээвэр 2.4 хувиар, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2.5 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 5.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Өнгөрсөн оны 1-р сарынхаас үнэ тарифын ерөнхий индекс 8.2 хувиар өссөн байна.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** Эхний 1 сард 101 эх амаржиж, 103 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс доогуур байна.

Халдварт өвчнөөр 217 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 137-оор өссөний дотор гахай хавдар, салхинцэцэг, тэмбүү, трихоминиаз, заг зэрэг өвчлөлүүд өссөн байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 792 болж урьд оны мөн үеэс 40-н хүнээр хасагдсан байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 73.4 хувь нь 15-34 насны залуучууд байна. Боловсролын хувьд 24.1 хувь нь дээд, 2.5 хувь нь тусгай дунд, 39.5 хувь нь бүрэн дунд, 6.4 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 1 сард 25 хүн шинээр бүртгүүлж, 13 хүн ажилд орсон байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** : Эхний 1 сард 32 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж, 3 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 7.7 сая төгрөгийн хохирол учирсны 16.3 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 22 хүн холбогдон сэжиглэгдсэний 18.2 хувь нь согтуугаар, 9.1 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 195 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 43 хүнээр буурсан байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 17 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

